

ДИЛАВ ХУТАГТЫН ХЯТАДАД ӨНГӨРҮҮЛСЭН ОН ЖИЛУУД

Өвөр Монголын шинэ үеийн түүхэнд дурдагддаг Дилав хутагт Жамсранжавын нэрийг хүмүүс андахгүй. Тэрбээр XIX зууны эцсээс XX зууны дунд хүртэлх үймээн самуунтай цаг үед амьдарч байсан бөгөөд тухайн үед Ар, Өвөр Монголд болж байсан түүхэн олон үйл явдлыг нүдээр үзэж биеэр туулжээ. Түүний туулсан амьдрал үлгэр мэт адал явдалтай бөгөөд нууцлаг адармаатай юм. Хятадын холбогдох эх сурвалжуудаас үзэхэд Дилав хутагтыг “Ар Монголын цагаач хутагт” буюу “олон улсын тагнуулч” хэмээн нэрлэж байжээ. Харин эх орон нь болох Монгол Улсад өнгөрсөн зууны 90-ээд он хүртэл түүнийг “хувьсгалын эсэргүү”, “эх орноосоо урвагч”, “империалистуудын гар хөл” хэмээн цоллож байв. Дээр дурьдсан хоёр жишээнээс түүний туулсан амьдрал ихээхэн ээдрээтэй, зөрчилтэй байсныг харж болох юм. Дилав хутагтын амьдрал үйл ажиллагааг бүрэн хэмжээгээр тусгасан ном зохиол одоо хүртэл хараахан хэвлэгдээгүй байна. Барууны зарим сонин сэтгүүл болон Монгол Улсад түүний намтар, дурдатгалыг нийтэлж байгаа боловч тэдгээр нь Дилав хутагтын Монголд амьдарч байсан үеийн тухай өгүүлсэн байх ба Өвөр Монголд өнгөрүүлсэн амьдралын талаар огтхон ч дурдаагүй байна. Энэхүү өгүүлэлд Дилав хутагтын Өвөр Монголд байх үеийн амьдрал, үйл ажиллагааны талаар бага ч болов дурдахыг зорьсон болно.

Дилав хутагтыг Монголын хуулийн байгууллагаас Япон, Хятадтай сүлбэлдэн ардын хувьсгалт засгийг унагахыг оролдсон “Эрэгдэндагвын хэрэг” гэгчид холбогдуулан 1930 оны намар хоёр жилийн тэнсэн харгалзах ялаар шийтгэжээ. Энэ хугацаанд дахин алдаа гаргавал цаазлагдах болно гэж түүнд сануулж байв. Энэ үед Дилав хутагт эд хөрөнгөө худалдан унаа хөсөг бэлтгэж, 1931 оны 2-р сарын 26-ны өдөр бараа бологч Гэндэн, Намжил, Халзан, Бүдүүн нарын хамт Дорноговь аймгийн Модон овоо хэмээх газраар хил даван Өвөр Монголын Улаанцав аймгийн Дунд гүний хошуунд оргож ирснээр харийн газраар цагаачлах амьдрал нь эхэлжээ.

Тэрээр Өвөр Монголд ирээд Улаанцав аймгийн Дунд гүний хошууны ван гүн нартай уулзаж, өөрийн “оргож ирсэн” байдлаа тайлбарлан энэ хошуунд оршин суух зөвшөөрөл авчээ. Удалгүй Дархан бэйлийн хошууны шар, хар ихэс дээдэстэй танилцан улмаар Батхаалга хийдэд суух болсон байна. Удалгүй 1932 оны 4-р сард IX Банчин богд Улаанцав аймгийн Ён (Ёндонванчиг) вангийн урилгаар Батхаалга хийдэд шарын шашны том хурлыг эрхлэн хурж хагас жил гаруй суужээ. Энэ хугацаанд Дилав хутагт Банчин богдын итгэлийг хүлээж чадсан байна. Тэрээр хожим нь Банчин богдын хамбын тэнхмийн Монголын

хэргийг хариуцсан эрхлэгч болсон гэсэн мэдээ бас бий. Дилав хутагт 1932 оны 4-р сард Луоян хотод болсон улсын хэмжээний хуралд оролцож, мөн оны сүүлээр Банчин богдын хамт Наньжин хотод очсон байна. Наньжинд байх хугацаандаа Банчин богд Хятадын баруун хязгаарын ухуулах төлөөлөгчөөр томилогдож, Дилав хутагт Гоминьданы засгийн газрын Хууль тогтоох хорооны гишүүн (1933 оны 1-р сараас 1935 оны 1-р сар хүртэл) болсон байна. Үүний дараа Дилав хутагт Банчин богдыг дагаж Хятадын зүүн хойд хэсэг болон Өвөр Монголын нутгаар нэлээд явжээ. Ердийн үедээ тэрээр Өвөр Монголын баруун хэсэгт Ар Монголоос ирсэн цагаач иргэдийнхээ дунд амьдарч байжээ. Банчин богд 1937 онд Хөхнуурт таалал төгсөх хүртэл тэд тасралтгүй харилцаж байв. Зарим хүний өгүүлснээр тэр жил Дилав хутагт Хөхнуурт очсон гэдэг.

Дилав хутагт Өвөр Монголд ирснийхээ дараахан “дээд хэмжээний өөртөө засах” хөдөлгөөнийг удирдаж байсан Дэ (Дэмчигдонров) вантай танилцаж, түүний итгэл хүндэтгэлийг хүлээсэн байна. Түүнийг 1932 оны сүүлчээр Наньжин хотод очиход Дэ ван тэнд байж Өвөр Монголын өөртөө засах эрхийн төлөө тэмцэхийг монголчуудад уриалж байв. Энэ үеэр тэд байнга харилцаж байсан бөгөөд Дэ ван Дилав хутагтаас Өвөр Монгол өөртөө засч болох эсэхийг асуухад “Ар Монгол тусгаар тогтнон өөртөө засч болж байхад Өвөр Монгол яагаад болдоггүй юм” гэж хариулжээ. Энэ үг нь Дэ вангийн санаанд ихэд нийцэж, Өвөр Монголын өөртөө засах эрхийн төлөө тэмцэх итгэл зоригийг нь улам бадраасан байна. Түүнээс хойш Дилав хутагт Өвөр Монголд байхдаа Дэ вантай байнга хамтран ажиллаж, түүний удирдсан олон чухал үйл ажиллагаанд оролцож, хариуцлагатай даалгаваруудыг нь гүйцэтгэж байсан бөгөөд түүний итгэлийг олсон цөөн хэдэн зөвлөхүүдийн нэг нь болжээ.

Дэ ван Японтой холбоо тогтоохоор шийдээд 1935 оны 12-р сард өөрийн биеэр “Манж улс”-ын Синьзинд очиж, Квантуны армийн командлагч болон штабын даргатай уулзан “Япон, Монголын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр” хийсэн бөгөөд японы тал Өвөр Монголын баруун хэсгийн монгол хошуудыг дэмжиж, урьдаар тусгаарласан байдлыг буй болгоод дараа нь “Монгол улс”-ыг байгуулна гэж тохиролцсон байна. Мөн цэргийн хэрэгцээнд зориулан япончууд 500 мянган юанийн тусламж өгч, 5 мянган буу нийлүүлэхээр болжээ. Дэ ванг дагалдан явж энэ үйл ажиллагаанд оролцсон хоёр монгол хүний нэг нь Дилав хутагт нөгөө нь үнэн хэрэгтээ Квантуны армийн тагнуул болоод байсан Тогтох нар юм. Үүнээс Дилав хутагт нь Дэ вангийн итгэл найдварыг хүлээсэн нөлөө бүхий хүн байсныг харж болно. Дэ ван Дилав хутагтыг бишрэн хүндэтгэж, ажил хэргээ

түүнтэй байнга зөвлөж байжээ. Японы тагнуулын байгууллага 1936 оны эхээр Өвөр Монголд ирсэн У Хэлинг (өөртөө засах хөдөлгөөний гол удирдах зүтгэлтнүүдийн нэг) нууцаар хороохоор төлөвлөж байсныг Дэ ван мэдээд Дилав хутагттай зөвлөн ярилцаж түүний амь насыг хамгаалан авч үлдсэн байна. У Хэлин Дэ ванд ихэд талархаж түүний гол хамтран зүтгэгчдийн нэг нь болжээ.

Дэ ван японы түрэмгийлэгчдийг түшиглэх үедээ тэдний цэргийнхэнтэй нэлээд зөрчилдөж эхэлсэн нь Дилав хутагтын анхаарлыг татжээ. Дэ ван 1936 онд Дэхуа хотод Монголын цэргийн засгийн газар байгуулах үед Дилав хутагт түүнд хандаж “Хэрэв чи японтой хамтран ажиллаж чадахгүй бол эртхэн больсон нь дээр. Дэлхийн улс орнуудаар явж, монголын асуудлыг танилцуулан ухуулж, олон улсын улс төрийн тавцанд гаргах хэрэгтэй. Олон улсын дэмжлэгийг олох нь дан ганц японоор туслуулснаас хавьгүй илүү үр дүнтэй...” гэж хэлж байжээ. Үүнээс үзэхэд тэрээр ерийн нэгэн шашны хутагт биш бас ч холын хараатай улс төрийн зүтгэлтэн байсан нь тодорхой байна. Дэ ван хэдэн жилийн дараа Монгол хязгаарын холбоот хороо байгуулах асуудал дээр японы цэргийнхэнтэй дахин ширүүн зөрчилдөх үедээ чухам хаашаа явах вэ гэдгээ тунгаан бодсон тухайгаа өөрийн дурсамжид бичихдээ “ЗХУ болон БНМАУ-д очихыг хүсэхгүй, Хятадын коммунист намд бууж өгөх тухай бодох ч хэрэггүй учир яаж ч бодоод Чан Кайшиг түших нь дээр гэж үзсэн юм...” гэжээ. Ингээд японы цэрэг, цагдаа, тагнуулынхны хатуу хяналттай нөхцөлд Дилав хутагт Дэ вангийн хүсэлтээр Хөххотод очиж, Чунцин дэх Гоминьданы талтай холбоо барих амь өрссөн үүргийг биелүүлсэн байна. Гэвч энэ үйл ажиллагааг японы цэргийнхэн илрүүлсэн тул үүнд оролцсон зарим хүмүүс зугтаж, нэг хэсэг нь баригдаж хоригдох буюу цаазлуулсан байна. Дэ ван ч аргагүй байдалд орж японы талд үнэн байдлаа хэлж, тэдний “эршөөл”-ийг хүртжээ. Энэ хэрэг явдлын дараа Дилав хутагт Чунцинд нууцаар очиж, Дэ вантай харилцаагаа хэсэг хугацаанд тасалсан юм шиг байлаа. Хятадын эх газар чөлөөлөгдөхөөс өмнө буюу 1949 оны эхээр хувь тавилан тэр хоёр хүнийг Наньжин хотноо дахин уулзуулж, тэд байнга харилцах болов. Энэ үедээ Дилав хутагт Энэтхэгт очно гэж Дэ ванд хэлж байсан боловч дараа нь О.Латтиморын урилгаар АНУ руу явахаар шийдсэн байна. Дэ ван Дилав хутагтад монголоор бичсэн итгэмжлэлээ гардуулж, өөрийн хувийн төлөөлөгчөөр Америкт үйл ажиллагаа явуулж, олон талын дэмжлэг тусалцааг эрэлхийлэхийг түүнээс хүссэн байна. Гэвч удалгүй Дэ ван гадагш гарч баривчлагдсанаар энэхүү итгэмжлэл дуусгавар болжээ.

Дилав хутагт Өвөр Монголд орж ирмэгцээ өөрийн нэр хүнд, нөлөөгөөрөө олны анхаарлыг татаж эхлэв. Тэр дундаа Өвөр Монголын баруун хэсэгт тусгай бодлого явуулахаар бэлтгэж байсан японы

цэргийнхний анхааралд нэн даруй өртсөн нь мэдээж юм. Квантуны армийн тагнуулын ажилтан Моришимо Ямомото зэрэг хүмүүс Дилав хутагтын сууж байсан Ар Монголоос зугтаж ирсэн Очирдарийн харьяа нутгаар байнга явдаг байлаа. Тэд Дилав хутагтыг өөртөө татаж, японы империалистуудын Ар, Өвөр Монголыг түрэмгийлэх бодлогод үйлчлүүлэх зорилготой байв. Японы Квантуны армиас 1935 оны 7-р сарын 25-нд баталсан “Өвөр Монголд хэрэгжүүлэх арга хэмжээ” хэмээх маш нууц баримт бичигт “Дилав хутагтыг өөртөө татан Дэ вантай нууцаар харилцуулж, нөлөө бүхий хүчийг бүрдүүлж үйл ажиллагаанд оруулаад Квантуны армиас Ар Монголын зүүн хэсгийн нутагт хэрэгжүүлэх ажиллагаанд туслалцуулна...” гэж дурдсан байлаа. Мөн “Дилав хутагтыг ашиглан Сенид баруун хошууны орчимд цэрэг цуглуулж, газар тариалан эрхлүүлэхийн зэрэгцээ цэргийн бэлтгэл хүч болгон Квантуны армийн явуулах ажиллагаанд оролцуулна...” гэж заажээ. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд 1939 онд Квантуны арми Ар Монголоос зугтан Өвөр Монголын Сенид баруун хошуунд ирсэн Ганжуурваа хутагтын албат 100 өрх айл, Дархан хошуунд байсан Очирдарь хутагтын 80 өрх болон Улаанцав аймгийн Дунд гүний хошууны 20 өрх малчдыг нийлүүлж, Сенид баруун хошууны нутаг дэвсгэрт Дилавын хошууг байгуулсан байна. Гэвч Дилав хутагт Өвөр Монголоос явсан тул хошуу даргын үүргийг Намсрай гэдэг хүнд хариуцуулсан байна.

Дилав хутагтыг Өвөр Монголд байх хугацаанд японы цэргийнхэн түүнийг ашиглаж олон нийтийг хууран мэхлэх томоохон ажиллагаа явуулахаар сэдэж байжээ. Дэ вангийн цэргийг захирч байсан Ли Шоусинь дурдатгалдаа “Намайг 1938 оны намар Дэ вангийн хамт Японд анх удаа айлчлахын өмнө Дилав хутагт надад хэлэхдээ “Ар Монголын Живзундамба хутагт таалал төгсөөд түүнийг залгамжлах хүн үгүй байгаа тул япончууд Дэ вангийн гуравдахь хүүг тодруулах санаатай байна. Энэ ажилд 150 мянган юань төсөвлөөд эхний ээлжинд 70 мянган юанийг Бээжинд суугаа Английн элчин сайдын яамаар дамжуулж Түвэдийн Далай ламд гуйвуулах ажлыг надад даалгалаа. Намайг эхлээд өөрийн биеэр Лхасад очиж энэ ажлыг зохицуул гэж байна. Далай лам үүнийг хүлээн зөвшөөрсний дараа үлдсэн 80 мянган юанийг нь гуйвуулах юм...” хэмээн ярьж байсан. Дилав хутагт Дэ ванг зөвшөөрвөл Бээжинд очиж мөнгийг гуйвуулаад усан онгоцоор Энэтхэгээр дамжин Түвэдэд очино гэж байсан боловч түүнээс хойш бараа сураггүй болсон...” гэж бичсэн байна.

Ойрын жилүүдэд Монгол Улсад хэвлэгдсэн материалаас үзэхэд Живзундамба хутагтын хойд дүр Түвэдэд тодорсон гэх яриа гарсан тул Дилав хутагт 1939 оны өвөл үнэн худлыг нь тодруулахаар Лхас

хотод очихоор төлөвлөж байжээ. Тэрээр Намжилдорж, Жамбалдорж, Гончиг зэрэг хүмүүсийнхээ хамт Шанхай хотод очиж бэлтгэл ажлаа хийсэн байна. Ингээд яг явах гэж байхад нь Гоминьданы холбогдох байгууллагаас Дилав хутагтыг Чунцин хотод ир хэмээн дуудсан байна. Иймээс тэрээр бараа бологсодоо усан замаар Лхас руу явуулаад өөрөө Гоминьданы тагнуулчдыг дагалдан Чунцин хотод очжээ. Тэнд түүнийг хэсэг хугацаанд асууж байцаан шалгаад суллаж, Гоминьданы засгийн газарт ажиллуулсан байна. Үүнээс үзвэл Дилав хутагтыг гоминьданы тал Чунцинд албадан аваачсан бололтой. Гэтэл О.Латтимор энэ явдлыг өөрөөр тайлбарласан байна. Түүний үзсэнээр Дилав хутагт тухайн үед япончуудын бодлогыг хэрэгжүүлэгч болохоос болгоомжилж, тэдэнтэй холбоотой аливаа ажил албанаас зайлсхийж байжээ. Түүнийг Чунцинд очихоос өмнө япончууд улсдаа айлчлуулж өндөр хэмжээнд хүлээн авсан байна. Дилав хутагтын Японоос Бээжинд ирсэн даруйдаа Шанхайд очиж, тэндээсээ далайгаар Гонконгд хүрээд Чунцинд буцаж ирснийг нь сайн дураараа Чунцинд очсон хэрэг юм гэж үзсэн байна. Энэ нь бодит байдалд илүү ойр дүгнэлт байж болох юм.

Сүүлийн үед Монгол Улсаас ил болгосон архивын баримтаас үзэхэд тухайн үед Дилав хутагт БНМАУ-ын Дотоодыг хамгаалах газрын гадаад тагнуулын албаны даалгавараар Японы цэргийн түрэмгийлэл, Гоминьдан, Банчин богд болон Ар Монголын цагаачдын байдлыг тагнахаар Хятадад орж ирсэн байна. Дилав хутагт Өвөр Монголд ирээд Чунцин руу явтлаа Монголын талтай харилцаа холбоотой байжээ. Монголын тал Дилав хутагт ба түүний удирдлагад ажиллаж байсан хүмүүсээр дамжуулан японы түрэмгийлэгчид болон гоминьданыхан Банчин богдыг ашиглаж Ар Монголын чиглэлээр явуулж байсан үйл ажиллагааны байдлыг сайн мэдэж байлаа. Гэтэл Дилав хутагтын ойрын хүн Банчин богдын талд үнэн байдлыг илчилсэн байна. Монголын тал 1938 оноос хэд хэдэн удаа хүн томилон явуулж, Дилав хутагттай холбоо барихаар оролдсон боловч тэд япончуудад баригджээ. Тэдний заримыг нь хутагт суллуулж, зарим нь үүрэг даалгавартай ирснээ хүлээж цаазлагдсан байна. Түүнчлэн Дэ ван Дилав хутагтыг Хөххот руу явуулж гоминьданы талтай холбоо бариулсан хэргийг япончууд илрүүлсэн нь түүнийг туйлын аюултай байдалд оруулсан байна. Түүний Чунцин руу явсан жинхэнэ учир шалтгаан нь энэ байж болох юм..

Нэг үгээр хэлвэл Дилав хутагт Чунцинд очсонхоо дараа Монголын талтай харилцаа холбоогоо тасалж, Өвөр Монголоос ч холдсон байна. Ингээд удалгүй Гоминьданы засгийн газарт алба хаших болжээ. Тэрээр 1947 он хүртэл Монгол-Түвэдийн хорооны гишүүн, гурав, дөрөв дэх удаагийн Улс төрийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн бөгөөд улс төрийн ажилтан, Гоминьданы засгийн газрын зөвлөх зэрэг ажлуудыг хийж

байлаа. Чунцинд байх хугацаандаа тухайн үед Чан Кайшийн зөвлөх байсан О.Латтимортой хамт сууж байжээ. Тэд 1931 оны өвөл Бээжинд анх танилцсан тухай О.Латтимор дурссан байдаг. Чунцинд хамт байхдаа тэдний нөхөрлөл улам бэхжиж, хоорондоо байнга монгол хэлээр ярилцан санал бодлоо солилцож байжээ. О.Латтимор 1944 онд АНУ-ын дэд ерөнхийлөгчийг дагалдан Чунцинд ирэхдээ Дилав хутагттай Хятадын дотоод байдлын талаар санал бодлоо солилцож байжээ. Тухайн үед Дилав хутагт японыг эсэргүүцэх дайн дууссаны дараа Хятадад иргэний дайн зайлшгүй гарна гэж үзэж байв. Тэрээр ХКН ялалт байгуулна гэдэгт төдийлөн итгэхгүй байсан боловч Чан Кайши зайлшгүй ялагдана гэж үзсэн бөгөөд дараа нь Коммунист нам эрх барина, эсвэл холбооны засгийн газар байгуулагдана гэж таамаглаж байжээ. Түүний таамаглал зөв байсныг хожмын үйл явдлууд нотолсон билээ.

Дилав хутагт Чунцинд байх хугацаанд түүний амьдралд хамгийн эмгэнэлтэй нэгэн үйл явдал болсон байна. Гоминьданы засгийн газар Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсний дараа 1946 оны эхээр Сүрэнжав тэргүүтэй БНМАУ-ын засгийн газрын төлөөлөгчид Чунцинд хүрэлцэн ирэв. Төлөөлөгчдийг онгоцны буудал дээр угтах хүмүүсийн дунд Дилав хутагт байжээ. Тэрээр Сүрэнжавд ойртон очоод “Би Дилав хутагт байна. Би хэдийгээр хувраг хүн боловч эх орон минь тусгаар тогтнолоо олсонд туйлын их баярлаж байна. Монголын ард түмэнд өлзийтэй өрөөл дэвшүүлье” гэхэд Монголын төлөөлөгчид түүнийг огт ойшоож үзсэнгүй. Дараа нь Дилав хутагт төлөөлөгчдийн байрласан “Ялалт” зочид буудалд очиж Сүрэнжавтай уулзах гэсэн боловч ажил ихтэй гэдгээр шалтаглан уулзаагүй байна. Энэ явдал Дилав хутагтыг туйлын эмгэнэлтэй байдалд оруулж, хожим нь түүний нутагтаа буцаж чадалгүй эцэстээ АНУ-д цагаачилсан гол шалтгаан болсон байна. Сүрэнжавын хожим өгүүлснээр төлөөлөгчдийг Хятад руу явахын өмнө Х.Чойбалсан түүнтэй ганцаарчлан уулзахдаа “Дилав хутагт та нарыг хайж ирж магадгүй. Түүнд нүүр өгөх хэрэггүй. Түүнтэй харилцвал шийтгэл хүлээх болно шүү...” гэж анхааруулсан байжээ. Дилав хутагт Монголын төлөөлөгчидтэй уулзаж, нутагтаа буцаж очих боломжийг эрэлхийлэх гэсэн боловч ийнхүү хана мөргөх мэт болов. Монголын тал Дилав хутагтад хүйтэн хөндий хандсан нэг шалтгаан нь бараа бологсодын нь дотор түүнийг хянах үүрэгтэй хүн байсанд оршино. Наньжин хотод 1932 оны сүүлээр очсоны нь дараа түүнийг харж ажиглах үүрэг бүхий бараа бологч хоёр хүн Монголын тагнуулын байгууллагад Дилав хутагт Бээжинд очиж японы тагнуултай уулзан Монголын тухай мэдээ өгсөн, Наньжин дахь Гоминьданы засаг захиргааны цэргийн албан тушаалыг хүлээж, 30 мянган юанийн шан авсан, цэрэг элсүүлж Монголд довтлохоор бэлтгэж байсан гэх зэргийг

мэдээлсэн байна. Дараа нь Монголын тагнуулын байгууллага Дилав хутагт Японд урилгаар айлчилсан, япончуудын даалгавараар Түвэдэд очсон, Монголд шашин, сүм хийдийг устгаж, лам нар болон энгийн иргэдийг баривчлан хэлмэгдүүлсэнд дургүйцлээ илэрхийлсэн гэх зэрэг мэдээллүүдийг авсан байна. Мөн түүнийг Английн болон Гоминьданы тагнуулын албадад баривчлагдан саатуулагдаж байсан тухай мэдээллийг ч авч байжээ. Дилав хутагт Чуншинд очоод Монгол болон Өвөр Монголтой харилцаагаа тасалсан тул Монголын тал түүний байдлыг мэдэх аргагүй болж, аажимдаа түүнийг урваж, гадаадын тагнуулын байгууллагын гар хөл болсон байж магадгүй гэж сэжиглэх болсон байна. Иймээс Монголын төлөөлөгчид түүнтэй уулзахаас татгалзаж, эцсийн эцэст тэрээр эх нутгаасаа холдож, далайн чанадад цагаачлан гарсан байна.

Энэ явдлын дараа Дилав хутагт дайны дараах богино хугацаанд Гоминьданы засгийн газар нийслэлээ шилжүүлж байсан үеийг ашиглаж, 1946 оны 3-р сард дахин Түвэд руу мордсон байна. Тэрбээр Шанхайд танилцсан Английн хоёр иргэний дэмжлэгээр Гуанжоу, Гонконгоор дамжин 4-р сард Түвэдэд очжээ. Лхасад тэрээр наймдугаар Живзундамба хутагтын хойд дүр болох хүнтэй уулзсан гэсэн яриа бий. Дилав хутагт буддын шашны зан үйлийн дагуу Лхасаас 30 километрийн зайд байх Ламцо нууранд очиж шинжсэн боловч тодорхойлж чадаагүй байна. Лхасад байхад нь 14 дүгээр Далай лам түүнийг хэд хэдэн удаа урин уулзаж, ихэд хүндэтгэл үзүүлж байсан гэдэг. Монголын зарим эрдэмтний өгүүлснээр тэрээр тухайн үед Далай ламын багш болон зөвлөх болж байжээ. Лхасад энэ удаа очихдоо Дилав хутагт Далай ламтай холбоотой болж, энэхүү харилцаа нь түүнийг таалал төгсөх хүртэл тасраагүй бололтой.

Түвэд, Энэтхэг, Балба зэрэг газруудаар жил гаруй аялаад Дилав хутагт 1947 оны 11-р сард Гоминьданы засгийн газар байрлаж байсан Наньжин хотод буцаж иржээ. Түүнийг энд жил гаруй байх хугацаанд Хятадын нөхцөл байдалд түүхэн өөрчлөлт гарч эхлэв. Хятадын ард түмний чөлөөлөх дайн шийдвэрлэх шатандаа шилжиж, Чан Кайшийн Гоминьданы засгийн газар сүйрлийн ирмэгт тулав. Энэ үед Дилав хутагт Хятадын коммунист нам тун удахгүй улсын засгийн эрхийг гартаа авна гэдгийг мэдэж байсан нь тодорхой. Туулж өнгөрүүлсэн амьдралын ээдрээт замаа бодоход түүнд шинээр мэндлэх Хятад усад амьдрахад хэцүү санагдсан бололтой. Тэрээр Энэтхэг рүү явах бодолтой байгаа тухайгаа О.Латтиморт захидлаар мэдэгджээ. О.Латтимор захидлыг нь хүлээн авмагцаа түүнийг АНУ-д ирэхийг урьсан байна. Дилав хутагт 1949 оны 2-р сард Хятадын паспортоор АНУ-д очжээ.

Дилав хутагт Жамсранжав үймээн самуун, өөрчлөлт хувиралт ихтэй түүхэн цаг үед амьдарч, монгол нутагт өрнөж байсан ээдрээ төвөгтэй олон үйл явдлыг нүдээрээ үзэж, биеэрээ туулсан байна. Тэрээр хэд хэдэн улс орны харилцан адилгүй улс төрийн бүлэглэлүүд болон нийгэм, шашны хүчнүүдийн дунд байж, тэдний хоорондын эрх ашгийн зөрчил болон харилцааг ашиглаж чадсан нь түүний билэг авъяас, ухаан чадварыг харуулж байна. Дилав хутагтын бүхий л амьдрал, үйл ажиллагааны байдлыг бүрэн хэмжээгээр, үнэн мөнөөр нь дүгнэн бичихэд нэн бэрх билээ. Ялангуяа түүний Дэ ван, японы түрэмгий хүчин, Чан Кайшийн Гоминьданы засгийн газар, Далай лам, Банчин богд болон америкчуудтай хэрхэн харилцаж байсныг цаашид нарийвчлан судлах шаардлагатай байгаа юм.

Ашигласан материалууд:

1. Б.Жамсранжав. Гадаад Монголын улс төрийн дурсамж
2. “Дилав хутагтын намтар”
3. Г.Дүйнхэржав. Наян дөрвөн шидэтний нэг Дилав хутагт, УБ, 1991
4. “Дилав хутагт Жамсранжав”, УБ, 2001
5. “Хоёр их хутагт”, УБ, 1995
6. “Японы империалист түрэмгийллийн түүхийн эмхэтгэл”
7. “Дэмчигдонровын өчил”
8. “Ли Шоусиний дьурсамж”
9. Захчид Сэцэн. Миний мэдэх Дэ ван ба тухайн үеийн Өвөр Монгол
10. “БНХАУ-ын цэргийн улс төрийн ажилтны ном”

*Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны
хүрээлэнгийн “Мэнгу сюэ синьси” сэтгүүлийн 2003.№4*

*Хятад хэлнээс орчуулсан: Л.Түмэнцэцэг (ӨМИС-ийн Хөрш
улс судлах хүрээлэнгийн захирал, профессор),
Д.Зоригт (доктор (Ph.D), хятад судлаач)*